# ХЭНТИЙ АЙМГИЙН
# НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 22 өдөр Дугаар А/118 Жаргалант

## Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хэнтий аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.13, 2.1.4.2 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгсдийг дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, спортын идэвхийг нэмэгдүүлэх, сургуулийн 90 жилийн ойг угтаж төгсөгчдийн хамтын ажиллагаа, нөхөрлөлийг бэхжүүлэх, төгсөгчдийн спортын уламжлалыг хадгалж, үе үеийн төгсөгчдийг нэгтгэх зорилгоор зохион байгуулж буй “Norowlin Cup 2025” тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч | Д.Шижирмөнх | Засаг даргын орлогч |
| Нарийн бичиг | Г.Тэргэл | Нийгмийн бодлогын мэргэжилтэн |
| Гишүүдэд | Г.Хишигбаатар | Биеийн тамирын багш |
| | Ц.Жинжиймаа | ЕБС-ийн нийгмийн ажилтан |
| | Ю.Отгонзаяа | СӨБ-ийн дуу хөгжмийн багш |
| | Б.Сумъяа | Төрийн сангийн мэргэжилтэн |
| | Г.Баатархуяг | Байгаль хамгаалагч |
| | Г.Мягмарцогт | Мэдээллийн ажилтан |
| | Г.Ганцогт | Өвийн ажилтан |

2.“Norowlin Cup 2025” тэмцээнийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын 22-ны дотор боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501286